

## АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2020 он)

### **1. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202003/01. ИНЕГ-т; Харилцаа холбооны зохицуулах хороо-нд. /Safety recommendation 202003/01. МСАА; ХХЗХ/.**

Чикагогийн Конвенцийн Хавсралт 10 Aeronautical Telecommunications, V-р боть, 4.1.Utilization of frequencies above 30 MHz, “The need to provide for coordination between international and national utilization so as to ensure mutual protection from interference”; Радио долгионы тухай Монгол Улсын хуульд заагдсан долгионы давтамжийг хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах талаар тус тус заагдсан боловч иргэний нисэхийн салбарт хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна. Иймд ИНЕГ нь Харилцаа Холбооны Зохицуулах Хороотой “иргэний нисэхийн радио холбооны давтамж (117,975 – 137,000 МГц)-ийн ашиглалт, хамгаалалт”-ын талаар эрх зүйн зохицуулалтыг хийж хэрэгжилтийг хангах.

### **2. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202003/02. ИНЕГ-т . /Safety recommendation 202003/02. МСАА/.**

Нислэгийн хөдөлгөөний удирдлагын нэгж, секторын ажлын байрны Агаар-газар ангилалын радио холбооны давтамж дахь шуугианы нөлөөллийг багасгах, аюулгүй ажиллагааг дээшлүүлэх зорилгоор Чикагогийн Конвенцийн Хавсралт 10, Volume V - Aeronautical Radio Frequency Spectrum Utilization болон ИКАО-ын DOC 9718 Volume II - Frequency assignment planning criteria for aeronautical radio communication and navigation systems-ын дагуу радио холбооны давтамжийн хувиарлалт /офсет давтамж/-ын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангах.

### **3. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202012/03 ИНЕГ-т. /Safety recommendation 202012/03. МСАА/.**

Автомат хамааралтай ажиглалтын ADS-B системийг нислэгийн хөдөлгөөний удирдлагад ашиглах үеийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг агаарын тээвэрлэгчид /нисгэгч, агаарын хөлгийн инженер/-тэй хамтран шинэчилэн боловсруулж хэрэгжүүлэх.

### **4. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202012/04 ИНЕГ-т. /Safety recommendation 202012/04. МСАА/.**

Автомат хамааралтай ажиглалтын ADS-B системийн найдвартай ажиллагааны иж бүрэн хэмжээний /GPS-ийн мэдээлэл, газрын болон агаарын хөлгийн тоноглол/ судалгааны тогтолцоог бүрдүүлж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

### **5. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202012/05 ИНЕГ-т. /Safety recommendation 202012/05. МСАА/.**

Агаарын хөлгийн навигацийн RAIM-ийн мэдээлэлийн хэллэгийг Нислэгийн хөдөлгөөний удирдлагад ашиглах стандарт зааварчилсан хэллэгийн зөвлөмжийн цуврал 3Ц-172 –д тодорхой тусгаж өгөх.

**6. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202012/06 ИНЕГ-т. /Safety recommendation 202012/06. МСАА/.**

Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын сектор (Төв, Дорнод, Говь, Мөрөн)-ын үйл ажиллагааны зааврыг нислэгийн хөдөлгөөний удирдлагын ADS-B системийг ашиглах явцад илэрсэн нөцөл байдал, нисэхийн мэдээллийн эмхтгэл-НМЭ болон бусад бодит байдалд нийцүүлэн өөрчлөлт, шинэчлэлтийг хийж, боловсруулан хэрэгжүүлэх.

**7. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202012/07 ИНЕГ-т. /Safety recommendation 202012/07. МСАА/.**

Сансрын навигацийн GPS-ийн RAIM Prediction тодорхойлох тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах, байнгын ажиллагаанд байлгах, түүний мэдээллийг авах, боловсруулах, хянах, түгээхтэй холбогдсон тогтолцоог бүрдүүлэх.

**8. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202012/08 ИНЕГ-т. /Safety recommendation 202012/08. МСАА/.**

Монгол улсын нутаг дэвсгэр дахь Нислэгийн замын агаарын орон зай дахь сансрын хиймэл дагуул GPS-ын мэдээллийг авах асуудлыг судалж хэрэгжүүлэх.

**9. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202012/09 ИНЕГ-т. /Safety recommendation 202012/09. МСАА/.**

Батлан хамгаалах болон бусад холбогдох байгууллагуудтай сансрын навигацийн GPS-ийн долгионы найдвартай ажиллагаанд хөндлөнгийн нөлөөлөл үүсэх магадлалаас хамгаалахтай холбогдолтой гэрээ, хэлцэл хийж хэрэгжүүлэх

**10. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202012/10 ИНЕГ-т. /Safety recommendation 202012/10. МСАА/.**

Нислэгийн хөдөлгөөний удирдлагад ашиглах Автомат хамааралтай ажиглалтын ADS-B системийн байнгын хяналт, удирдлага, зохицуулалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

**11. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202012/11 ИНЕГ-т. /Safety recommendation 202012/11. МСАА/.**

Монгол Улсын нутаг дэвсгэрт нислэгийн хөдөлгөөний удирдлагад Автомат хамааралтай ажиглалтын систем (ADS-B)-ийн найдвартай ажиллагаа бүрэн хангагдах хүртэл бодит ажиглалтын радиолокаторыг үндсэн системээр ашиглах.